*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ЭМТ 2 ДУГААР БАГИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН ЧАДРААБАЛЫН ЦЭВЭЛМААГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Хүрэх түвшин | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Хууль болон бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.Өрхийн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур, дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучлах | 1.1.1.Хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй өрхийн орлого нэмэгдүүлсэн өрхийн тоогоор | 2 | 2 | Хүнс, тэжээлийн хөтөлбөрт нийт 26 өрх хамрагдан үйлчилгээ авч байна. Хөтөлбөрт хамрагдсан иргэдээс 2 иргэнийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулсан. Мөн 18 иргэн тогтмол ажил эрхэлж, орлогын их үүсвэрээ нэмэгдүүллэн ажиллаж байна. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| | | 1.1.2.Түр болон нийтийг хамарсан ажлын байранд зуучилсан иргэний тоогоор | 10 | 10 | Нийтийг хамарсан ажлын хүрээнд: Нийтийн эзэмшлийн талбайд мод тарих ажилд 4 иргэнийг хамруулан ажиллуулсан.<br><br>Мөн улирлын чанартай түр ажилд: Усалгааны ажилд 10 иргэнийг зуучлан ажиллуулсан. Нийт **14** иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн түр ажлын байранд холбон зуучилсан байна. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 1.2.Багийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд баяжилт хийж, хөдөлмөр эрхлээгүй иргэдийг сургалтад хамруулах, ажилд зуучлах | 1.2.1.Хөдөлмөрт бэлтгэх болон мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухааны сургалтад хамрагдсан иргэдийн хувиар | 10% | 10% | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ” сургалтад: Хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэн, Ажилгүй 12 иргэн, ХЭБ үйлчилгээ авдаг 1 иргэн нийт 16 иргэн хамрагдан ажлын чиг баримжааны зөвлөгөө авсан. Мөн чадамжид суурилсан мэргэжлийн сургалтад хамруулах 24 иргэний судалгааг гарган ХХҮГ-ийн холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.Нийт хөдөлмөр эрхлээгүй нийт 150 иргэнээс: 65 иргэн мэргэжлийн чиг баримжаа олгох богино хугацааны сургалтад хамрагдсан. 25 иргэн мэргэжил олгох сургалтад хамрагдахаар бүртгүүлсэн байна. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| | | 1.2.2.Байнгын болон улирлын чанартай ажлын байранд зуучилсан иргэдийн тоогоор | 4 | 4 | Ажилд зуучлалын хүрээнд: Байнгийн ажлын байранд 4 иргэнийг амжилттай зуучлан ажилд оруулсан.Мөн ХХҮГ-аас хэрэгжүүлж буй иргэний санхүүжилтын төсөлд 5 иргэнийг хамруулан шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилласан. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| | | 1.2.3.Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдын нийгмийн даатгал төлөлтийг нэмэгдүүлсэн иргэдийн тоогоор | 8 | 8 | Тайлант хугацаанд малчин 8 иргэн нийгмийн даатгалд хамрагдан шимтгэлээ төлж эхэлсэн байна. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |

Малчин - 130 -
Хувиараа - 110 -

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Арга хэмжээ 1.3.Ахмад настны нийгмийн оролцоог хангах | 1.3.1.Хөдөлмөр эрхэлдэг ахмад настны судалгаанд баяжилт хийсэн тоогоор | 6 | 8 | Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн судалгаагаар: Байгууллагад хөдөлмөр эрхэлж буй ахмад 18, хувиараа хөдөлмөр эрхэл буй ахмад 33, малчин ахмад 7 Ингэснээр нийт 58 ахмадын хөдөлмөр эрхлэлтийн судалгааг гарган баяжилт хийж, мэдээллийн санг шинэчилж баталгаажуулсан байна. | 2025.01.13 2025.12.01 | 100 |
| | | 1.3.2.Хөдөлмөр эрхэлдэг ахмад настны хувиар | 100% | 100% | Тайлан хугацаанд байгийн хэмжээнд нийт 378 ахмад бүртгэлтэй байна. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийн судалгааг гарган баяжилт хийж, мэдээллийн санг шинэчлэн ажиллаж байна. Зөвлөн туслах үйлчилгээнд 1 ахмад хамрагдан зөвлөгөө өгч ажилласан.Мөн төсөл, хөтөлбөрт хамрагдах хүсэлтийг 8 ахмад ирүүлсэн бөгөөд үүнээс 3 төсөл дэмжигдсэн байна. | 2025.01.13 2025.12.01 | 100 |
| | | 1.3.3.Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулахаар ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар | 80% | 80% | 1.Рашаан сувилалд 13 ахмад хамрагдсан.<br>2.Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар Шинээр асрагаанд 3 ахмад орж, 1 ахмад асран хамгаалагчаа сольж, 14 ахмад асрагаа сунгагдсан байна.<br>3.Ахмад настны хөнгөлөлтөд 36 ахмад хамрагдаж, суултуур, таяг авч, шүдний хөнгөлөлтөд тус тус хамрагдсан байна.<br>4.Цагаан сарын баярыг тохиолдуулан 90-с дээш насны 6 ахмадад гарын бэлэг гардуулсан. | 2025.01.13 2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 5.Харъяалалгүй 278 ахмадын судалгааг гаргаж, ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэнд хүргүүлэн ажилласан.<br>Нийгмийн халамжийн үйлчилгээнд ахмад настнуудыг хамруулан, тэдний нийгмийн оролцоог идэвхжүүлэн ажилласан байна. ханган ажилласан байна. | | |
| 4. | Арга хэмжээ 1.4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах | 1.4.1.Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 2 | 2 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж, тэдний нийгмийн оролцоог хангаң ажилласан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулагдсан арга хэмжээ, сургалтад иргэдийг идэвхтэй хамруулан ажилласан. Тухайлбал:<br>1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэлгэрэнгүй судалгаа, харааны бэрхшээлтэй иргэдийн судалгаа, тэргэнцэртэй иргэдийн судалгаа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаанд баяжилт хийн ажилласан.<br>2.“Хүний эрх-Хүртээмжтэй оролцоо” сарын аяны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон асран хамгаалагчдад “Зүрх сэтгэлийн боловсрол олгох ба цахим ур чадварыг нэмэгдүүлэх нь” сургалт зохион байгуулж 12 иргэн хамруулсан.<br>3. Харааны бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах цагаан таягтны өдөрлөгийг зохион байгуулж, тус өдөрлөгт 10 иргэн хамрагдсан | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна.<br>4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан өдөр УИХ-ын гишүүн Ж.Баясгалан хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй уулзалт зохион байгуулж тэдэнд чиглэсэн бодлого шийдвэрүүдийг танилцуулан, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцов. Уулзалтад 15 иргэн хамрагдсан.<br>5.Эрүүл мэндийн магадлан зөвлөлийн нээлттэй хаалганы өдөрлөгт хөгжлийн бэрхшээлтэй 10 иргэн хамрагдсан. | | |
| | | 1.4.2.Хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувиар | 40% | 40% | 1.''Зүрх сэтгэлийн боловсрол олгох ба цахим ур чадварыг нэмэгдүүлэх нь'' сургалтад багаас асран хамгаалагч 7, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 5, нийт 12 иргэнийг хамруулсан.<br>2.Хараагүйчүүдийн үндэсний холбооноос зохион байгуулсан сургалтад 3 иргэн хамрагдсан. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| | | 1.4.3.Соёл урлаг, спорт бусад арга хэмжээнд хамруулсан хувиар | 50% | 50% | 1.Ариунсанаа эмнэлэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үнэ төлбөргүй үзлэг оношлогоонд хамруулж ажилласан.<br>2.''Хүний эрх-Хүртээмжтэй оролцоо'' сарын аяны хүрээнд Элбэрэлт мед эмэгтэйчүүдийн эмнэлэгт хөгжлийн бэрхшээлтэй 20 эмэгтэйг үзлэгт хамруулав. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| | | 1.4.4.Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулахаар | 100% | 100% | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучлан ажилласан. Үүнд:<br>• Амьжиргаа дэмжих хурлаар | 2025.01.13 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар | | | 10 иргэн,<br>• Унааны хөнгөлөлтөд 6 хүүхэд хамрагдсан.<br>• Нуруу бүс, суултуур, бусад хэрэгсэл авах үйлчилгээнд 25 иргэн хамрагдсан. | 2025.12.01 | |
| | | 1.4.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалтын хувиар | 80% | 80% | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 17 байна. Үүнээс Ерөнхий боловсролын сургуульд 10 хүүхэд, 11-р тусгай цэцэрлэгт 2 хүүхэд, энгийн цэцэрлэгт 2 хүүхэд явж, сурч боловсорч, хөгжиж байна. Үлдсэн 3 хүүхэд нь байнгын асаргаанд байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 82%-нь сургууль цэцэрлэгт хамрагдсан. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| 5. | Арга хэмжээ 1.5.Хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх, үнэлгээ хийх дүгнэлт гаргах | 1.5.1.Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, гэр бүлд гэр айлчлал хийсэн өрхийн хувиар | 100% | 100% | Эрсдэлт өрхүүдэд хяналт, эргүүл хийх зорилгоор нийт 12 удаагийн эргэлт, эргүүлийг зохион байгуулж багийн Засаг дарга, багийн цагдаа, хэсгийн байцаагч, багийн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нар хамтран ажиллав. Эргэлт эргүүлийн үеэр өрхийн амьдрал ахуй, хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг судалж шаардлагатай арга хэмжээг хамтарсан багаар шуурхай авч ажилласан. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| | | 1.5.2.Хаагдсан кейсийн хувиар | 100% | 100% | Хүүхдийн тусламжийн утас 108-д ирсэн 4 кейс, мөн шинээр илрүүлсэн 8 кейсийг хамтад нь авч, нийт 8 кейс-ийн хүрээнд хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэв. Үүнээс **5** кейсийг амжилттай хаасан. Одоогоор 3 | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | кейсийг хаагаагүй бөгөөд дээр нь хамтарсан багийн ажил үргэлжилж байна.Кейсүүдийн хүрээнд хүүхдийн эрхийн хамгаалал, гэр бүлийн дэмжлэг, шаардлагатай зөвлөгөө мэдээлэл, нийгмийн үйлчилгээ үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулсан. | | |
| | | 1.5.3.Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 1 | 1 | 1.Тус багийн хамтарсан багаас гэмт хэрэг зөрчил, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрх, гэр бүлийн хүчирхийллийн талаар 2 удаа подкаст бэлтгэн олон нийтийн цахим сүлжээ, багийн группт нийтэлсэн. Уг подкастыг нийт 3213 иргэн үзсэн хандалттай байна. Подкастын агууллага нь хүүхдийн эрх хамгаалал, гэмт хэрэг зөрчилтэй холбоотой зөвлөмж мэдээлийг багтаасан байна.<br><br>2.Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 1 өрхийн хүүхдүүдэд Арвайхээр сумын ЗДТГ-аас хүнс, түлээ нүүрсний тусламж үзүүлсэн.<br><br>3.Тус багийн 2 малчин өрхөөс зорилтот бүлгийн өрхүүдэд хүнс, түлээ нүүрсний тусламж үзүүлж 5 өрхөд гурил будаа, 2 өрхөд 10 шуудай нүүрс өгсөн.<br>4.Аймгийн ХГБХХГазраас хүнсний дэлгүүрийн эзэд, худалдагч нарт зохион байгуулсан архи, согтууруулах ундаа, утаат тамхи, | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | электрон тамхи, бусад төрлийн мансууруулах бодисоос хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилготой "Хүүхдийн төлөө илүү хариуцлагатай, илүү сонор байцгаая" сургалтад багийн 4 дэлгүүрийн эзэд хамрагдав.<br>5.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, Хүүхэд хамгаалал, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 төрлийн постер, боршур бэлтгэж, 100 гаруй иргэнд түгээн ажилласан.<br>6.Дэлгэрэх дэнж 7-р багтай хамтран хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо, хүүхэд хамгааллын талаар сургалт зохион байгуулж 25 иргэн, хүүхэд хамруулав. | | |
| | | 1.5.4.Эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд сургалт зохион байгуулсан тоогоор | 1 | 1 | Хүүхэд хамгааллын талаар эцэг эх, асран хамгаалагчдад 3 удаагийн сургалт зохион байгуулсан.<br>1.Эмт 2 дугаар багаас 'Ухаалаг иргэн-Эрсдэлгүй нийгэм" сургалт зохион байгуулж 15 иргэн хамрагдсан. Тус сургалтаар эцэг эхчүүдэд сэтгэл зүйн эрүүл мэндийн сургалт орж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, электрон тамхины хор уршгийн талаар бэлтгэсэн гарын авлага боршур тараав.<br>2.Дэлгэрэх дэнж 7-р багтай хамтран Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо, хүүхэд хамгааллын талаар сургалт зохион байгуулж 25 иргэн хамруулав.<br>3.Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өдрийг тохиолдуулан ХГБХХГазартай хамтран "Хариуцлагатай эцэг, эх байя" арга хэмжээг зохион байгуулж багаас 5 иргэн хамруулсан.<br>4.Иргэдэд илүү ойр өдөрлөгийг багийн нутаг дэвсгэрт 2 өдрийн турш зохион байгуулж, арга хэмжээнд нийт 310 иргэн хамрагдаж, 4 төрлийн 400 гаруй гарын авлага тарааж иргэдийн хууль эрх зүйн мэдлэг,Хүүхэд хамгааллын хамтарсан багийн талаар ойлголт хандлагыг нэмэгдүүлсэн. Хүүхэд хамгааллын хамтарсан багаас санаачилсан иргэдэд хууль зүйн боловсрол олгох багц гарган иргэдэд хүргэж байна. Энэ багцын давуу тал нь, хүүхэд гэр, бүлийн жрх хамгааллын талаар иргэдэд нэг дор 5 хуулийн зохицуулалт, зүйл заалтын талаар мэдээлэл олгох | | |
| | | 1.5.5.Хайрлагдсан хүүхэд төслийн хэрэгжилтийн хувиар | - | 60% | "Хайрлагдсан хүүхэд" төслийн хэрэгжилтийн талаар зохион байгуулсан хэлэлцүүлэгт нийт **5 гэр бүл, 10 иргэн** оролцож хамрагдлаа. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| 6. | Арга хэмжээ 1.6.Гэр бүлийн хөгжил, төлөвшилд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | 1.6.1.Залуу гэр бүлийн хөгжил, төлөвшилд чиглэсэн сургалт арга хэмжээний тоогоор | 1 | 1 | Аймгийн ХГБХХГазраас Олон улсын гэр бүлийн өдөрт зориулан зохион байгуулсан "Хайраар холбогдсон амьдрал" арга хэмжээнд багаас 3 үеийн гэр бүлийн төлөөлөл оролцов. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| | | 1.6.2.Халуун ам бүл төслийн хэрэгжилтийн хувиар | - | 60% | Халуун ам бүл төслийн хэрэгжилтийн талаар зохион байгуулсан хэлэлцүүлэгт нийт **5 гэр бүл, 10 иргэн** оролцож хамрагдлаа. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Арга хэмжээ 1.7.Иргэдийг хорт зуршил, мансууруулах бодис, электрон тамхины хэрэглээг багасгах, сурталчилан таниулах | 1.7.1.АА (Архичид Аминчлахуй) бүлэгтэй хамтран ажилласан арга хэмжээний тоогоор | 1 | 1 | 1.Өвөрхангай аймаг дахь Архидалт мансуурлын эсрэг Ассоциацийн салбар НҮТББ, Сэтгэц нийгмийг сэргээн засах төвөөс зохион байгуулсан "Архины хамааралтай хүнд үзүүлэх сэтгэц-нийгмийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах" сургалтад хамрагдсан.<br>2.Өөртөө туслах бүлгэмтэй хамран ажиллах талаар Гэр бүлийн нийгмийн ажилтны хамт санал солилцон Зорилтот бүлгийн 2 айл өрхөөр орж зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.<br>3.Арвайхээр сумын ЗДТГазраас "Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх" сургалтад 4 хүнсний дэлгүүрийг хамруулсан. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| | | 1.7.2.Хорт зуршил, мансууруулах бодисын хэрэглээг багасгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоогоор | 2 | 2 | 1.Дэлгэрэх дэнж 7-р багтай хамтран "Ухаалаг иргэн-Эрсдэлгүй нийгэм" сургалт зохион байгуулж 15 иргэн хамруулсан. Тус сургалтаар иргэдэд тамхи, электрон тамхины хор уршгийн талаар сургалт орж, тамхины хор уршгийн талаар бэлтгэсэн гарын авлага тараасан.<br>2.Аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан "Эрүүл нийгмийг бүтээхэд эрчүүдийн оролцоо" өдөрлөгт багаас 5 иргэн оролцов.<br>3.ХГБХХГазраас зорилтот бүлгийн иргэдэд зориулсан сургалт, арга хэмжээ зохион байгуулагдаж 3 иргэн хамруулсан.<br>4.Хүүхдүүдэд "Утаат болон | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | электрон тамхи худалдан борлуулахгүй байх "Ашиг биш хариуцлагаа эрхэмлэе 14 хоногийн аянд багийн 4 дэлгүүр нэгдсэн. | | |
| 8. | Арга хэмжээ 1.8.Хүүхэд өсвөр үеийг осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | 1.8.1.Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээний тоогоор | 2 | 2 | 1.Дэлгэрэх дэнж 7-р багтай хамтран Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо, хүүхэд хамгааллын талаар болон сурагчдын амралт эхэлсэнтэй холбогдуулан хүүхдийг осол гэмтэлд өртөхөөс сэргийлэх тухай сургалт зохион байгуулж 25 иргэн, хүүхэд хамруулав. | 2025.01.13 2025.12.01 | 100 |
| | | 1.8.2.Нийтийг хамарсан баяр, тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 2 | 2 | 1.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Хүүхэд хүүхэддээ нөлөөлье" сургалт арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд "Эерэг хандлага", "Хүүхдийн эрх хамгаалал" сэдвүүдээр сургалт зохион байгуулж багийн дэлгүүр, байгууллага, хувь хүмүүстэй хамтран 60 хүүхдэд бэлэг гардуулсан.<br>2.Аймгийн ХГБХХГазраас Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан "Хайраар холбогдсон амьдрал" арга хэмжээг зохион байгуулж тус багаас 3 үеийн гэр бүлийн төлөөлөл оролцов.<br>3.Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдрийг тохиолдуулан ХГБХХГазартай хамтран "Хариуцлагатай эцэг, эх байя" арга хэмжээг зохион байгуулж багаас 5 иргэн хамруулсан. | 2025.01.13 2025.12.01 | 100 |
| | Арга хэмжээ | 1.9.1.Бэлгийн | | | "Ухаалаг иргэн-Эрсдэлгүй нийгэм" | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9. | 1.9.Иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх олон талт арга хэмжээ зохион байгуулах | замаар дамжих халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан иргэдийн хувиар | 20% | 20% | сургалт зохион байгуулж тус сургалтаар Уян сэтгэл ӨЭМТөвөөс халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Сургалтад нийт 15 иргэн хамрагдсан. | 2025.01.13 2025.12.01 | 100 |
| | | 1.9.2.Хуванцар савны хэрэглээнээс татгалзсан өрхийн тоогоор | 4 | 4 | "Эрүүл мэндийн экспо-2025" өдөрлөгийн хүрээнд Хуванцар савны хэрэглээ, түүний хор нөлөөг бусдад таниулах зорилгоор брошур тараан ажилласан. Мөн багаас зохион байгуулсан 2 сургалтаар иргэдэд брошур тараан ажилласан. Багийн иргэд хуванцар савнаас бага багаар татгалзаж өдөр тутмын амьдралдаа хүнсний зориулалттай ган савыг хэрэглэн 5 өрх хэрэгжүүлж байна. | 2025.01.13 2025.12.01 | 100 |
| **ХОЁР. "Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1.Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, бие бялдрын сорил авч цахим мэдээллийн санд баяжилт хийх | 2.1.1.Нийтийн биеийн тамираар хичээллэгчдийг нэмэгдүүлсэн хувиар | 10% | 10% | МУ-ын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд ахмад настны бие бялдрыг чийрэгжүүлэх, тэднийг хөдөлгөөний хомсдол болон халдвар бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх зорилготой "ХИЙН ДАСГАЛ"-аар багийн 8 ахмад хичээллэдэг. | 2025.01.13 2025.12.01 | 100 |
| | | 2.1.2.Бие бялдрын сорилд хамрагдсан 15-64 | 10% | 10% | 15-64 насны 1500 иргэн байгаагаас бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 80 иргэн хамрагдаж 15-64 | 2025.01.13 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | насны иргэдийн хувиар | | | насны иргэдээс эхний хагас жилд 5 хувь хамргадахаас 3 хувь буюу 90%-нь хамрагдсан байна.<br>15-64 насны иргэдээс бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 80 иргэн хамруулж, үүнээс эрэгтэй 24, эмэгтэй 32 иргэн хамрагдсан. Сорилд А-8, В-22, С-9, D-9, F-8 үнэлгээтэй байсан. Тус сорилын мэдээллийг Биеийн тамир, спортын улсын хорооны Өвөрхангай БТСГ-ийн цахим программд шивж оруулсан. | 2025.12.01 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2.2.Соёлын биет бус өв тээгчдийн судалгаанд баяжилт хийх шавь сургалтыг хөгжүүлж, өвлөн уламжлагчдын тоог нэмэгдүүлэх | 2.2.1.Морин хуурыг түгээн дэлгэрүүлэх сурталчилан таниулах арга хэмжээний тоогоо | - | 1 | 1.Суралцагч хот-Арвайхээр" өдөрлөгийг ЗДТГ, Насан туршийн суралцахуйн төв, Арвайхээр сумын ЗДТГ болон төр, төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. "Өв соёлоосоо суралцацгаая" өртөөн дээр морин хуураа сурталчилан багаас 1 иргэн хуураа хөглүүлэв.<br>2."Удмаа хайрлая, хуураа дээдлье" сургалт арга хэмжээг ахмадын хороо, насан туршийн суралцахуйн төв, 13 багийн нийгмийн ажилтнууд хамтран зохион байгуулан бөгөөд тус сургалтад 13 багийн 74 иргэн хамрагдсан байна. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| | | 2.2.2.Соёлын биет бус өв тээгчийг сурталчилан таниулах арга хэмжээний тоогоор | 1 | 1 | 1.Эмт 2-р багийн нэрэмжит "Нумт харваа"-ны "Шилжин явах цом"-ын төлөөх анхдугаар тэмцээн зохион байгуулагдав. Тус тэмцээнд 12 багийн нийт 70 гаруй ахмад харваачид оролцож Дэд байрт Эмт 2-р багийн харваачид байр эзэлсэн.<br>2.С.Төмөр, С.Төмөрбаатар нар | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шагайн нумт харваа биет бус өвийг тээн, шавь сургалтыг хөгжүүлэн, 7 хоногт 2 удаа багийн төвийн хурлын танхимд шагайн нумт харваа хичээллүүлж байна.<br>3.”Ахмадын урлагын наадам-2025” нэгдүгээр шатны шалгаруулалтад тус багийн ахмад настан уртын дуугаар оролцож бүсийн уралдаанд оролцох эрхээ гардан авсан. | | |
| | | 2.2.3.”Уншигч гэр бүл”-ийг нэмэгдүүлсэн тоогоор | 10 | 15 | Насан туршийн суралцахуй төвийн мэргэжилтэн 13 багийн нийгмийн ажилтан 13 багийн нийгмийн ажилтан хамтран уншигч гэр бүл нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус сургалтад нийт 74 иргэн хамрагдсан байна. Багийн хэмжээнд уншигч гэр бүлийг нэмэгдүүлэх, иргэдэд уншлагын соёлыг түгээх, гэр бүлийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Уншигч гэр бүл”-ыг шалгаруулах уралдаан зохион байгуулж, идэвхтэй оролцсон 5 гэр бүлийг бэлэг дурсгалын зүйлээр урамшуулсан. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| 3. | Арга хэмжээ 2.3.Өрхийн дунд угийн бичиг хөтлөлтийг эрчимжүүлэх сургалт арга хэмжээ зохион байгуулах | 2.3.1. Угийн бичиг хөтлөдөг өрхийн тоогоор | 3 | 5 | Угийн бичиг хөтлөх 10 иргэний нэрс гарган, энэ онд угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлэх талаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. Угийн бичиг тогтмол хөтлөж байгаа 3-5 иргэн байна.<br>Угийн бичиг хөтлөлтийн судалгаанд баяжилт хийж ажилласан. Эхний хагас жилд угийн бичгийн талаарх сургалтыг иргэдэд 2 удаа зохион байгуулсан. | 2025.01.13<br>2025.06.13 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2.3.2.Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоогоор | 2 | 2 | Угийн бичгийн хөтлөлт, түүний ач холбогдлын талаар багийн иргэдийг 2 удаагийн сургалтад хамруулж ажилласан. Үүнд:<br>1.Арвайхээр сумын Насан туршийн суралцахуйн төв, Уг удам, өв соёл НҮТББ-ийн тэргүүн Д.Бямбасүрэнтэй хамтран зохион байгуулсан угийн бичгийн сургагч багш бэлтгэх сургалтад 2 иргэн хамруулсан.<br>2.Дэлгэрэх дэнж 7-р баг, НТБНэгжийн багш С.Солонготой хамтран иргэдэд "Угийн бичиг хөтлөлт" сургалт зохион байгуулж 25 иргэн хамруулсан.<br>3.Арвайхээр сумын Насан туршийн суралцахуйн төв, Ахмадын холбоотой хамтран зохион байгуулсан "Өрх бүрт угийн бичиг" сургалтад хамрагдав.<br>4."Угийн бичиг-удам судрийн өв соёл" сургалт, арга хэмжээг ахмадын хороо, 13 багийн нийгмийн ажилтнууд хамтран зохион байгуулсан бөгөөд тус сургалтад 13 багийн 74 иргэн хамрагдсан байна. Сургалтын хүрээнд 13 багийн "Жишиг угийн бичгийн" үзэсгэлэн гаргасан байна. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| 4. | Арга хэмжээ 2.4.Сум багийн хэмжээнд туршлага болохуйц шинэ ажил санаачлан хэрэгжүүлэх | 2.4.1.Шинээр санаачилсан ажлын тоогоор | 1 | 1 | Иргэдэд илүү ойр өдөрлөгийг багийн нутаг дэвсгэрт 2 өдрийн турш зохион байгуулсан. Хүүхэд хамгааллын хамтарсан багаас санаачилсан иргэдэд хууль зүйн боловсрол олгох багц гарган иргэдэд хүргэж байна. Энэ багцын | 2025.01.13<br>2025.12.01 | 100<br>100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | давуу тал нь, хүүхэд гэр, бүлийн эрх хамгааллын талаар иргэдэд нэг дор 5 хуулийн зохицуулалт, зүйл заалтын талаар мэдээлэл олгох юмаа. | | |
| **ГУРАВ. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1.Жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах, дүгнүүлэх | 3.1.1.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Засгийн газрийн Хэрэг эрхлэх газрын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймаг, сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж төлөвлөгөөг гарган төсвийн шууд захирагчид хянуулж дүгнүүлсэн. | 2025.01.13 2025.12.01 | 100 |
| 2. | Арга хэмжээ 3.2. Хугацаатай албан бичиг, тайлан мэдээ, судалгааг бүрэн үнэн зөв гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэх | 3.2.1.Өргөдлийн шийдвэрлэлтийн хувиар | 100% | 100% | Энэ оны хагас жилийн байдлаар амьжиргаа дэмжих хурал 10 удаа хуралдаж байнгын асаргааны сунгалт 17, асран хамгаалагчаа солиулах 1, шинээр асрагаанд орсон 6, ӨТЭхийн тэтгэмж 2, тэжээгчээ алдсан тэтгэмж 1, нийт 27 иргэний өргөдлийг шийдвэрлүүлэв. | 2025.01.13 2025.12.01 | 100 |
| | | 3.2.2.Хугацаатай албан бичиг болон мэдээ хүргүүлсэн тоогоор | 100% | 100% | Нийт 30 хугацаатай албан бичиг ирснээс бүх бичгийн хариуг хугацаанд нь гаргаж, холбогдох албан тушаалтанд хүргэж ажиллалаа. | 2025.01.13 2025.12.01 | 100 |
| | | 3.2.3.Сарын ажлын мэдээний тоогоор | 12 | 12 | Багийн ажлын алба сарын ажлын мэдээг нэгтгэн **нийт 12 удаа** гаргасан байна. | 2025.01.13 2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Арга хэмжээ 3.3.Статистик мэдээ тайлан, тооллого судалгаа, мэдээллийн санд баяжилт хийх | 3.3.1.Нийгмийн зарим үзүүлэлт мэдээ | 6 | 6 | Үндэсний статистикийн программд шивэлт хийгдэх хугацаа болоогүй. Зорилтот бүлгийн иргэдийн нарийвчилсан судалгаанд баяжилт хийсэн. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| 4. | Арга хэмжээ 3.4. Ес зүйн болон ашиг сонирхолын зөрчилгүй ажиллах | 3.4.1.Иргэдээс ирсэн гомдол мэдээлэл ирүүлээгүй байх | 100% | 100% | Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчил гаргаагүй ажилласан байна. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| 5. | Арга хэмжээ3.5. Байгууллагаас зохион байгуулж байгаа олон нийтийн арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцох | 3.5.1.Зохион байгуулсан ажилд оролцсон хувиар | 100% | 100% | Байгууллагаас зохион байгуулагдаж буй аливаа арга хэмжээнд идэвхтэй оролцож байна. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| 6. | 3.6.Байгууллагаас зохион байгуулсан сургалт, судалгаанд хамрагдах | 3.6.1.Хамрагдсан хувиар | 100% | 100% | 1.Арвайхээр сумын ИТХ-аас зохион байгуулсан албан хаагчдын сургалт<br>2.Хиймэл оюун ухаанд чадавхижуулах сургалт<br>3.Мэдээллийн аюулгүй байдал, байгууллагын удирдлагын систем ашиглах сэдэвт сургалтад хамрагдсан. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ) -ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | "Эрүүл мэндийн Экспо-2025" өдөрлөг | Тухай бүр ажиллах | 100% | 100% | Монос групп ХХК-аас зохион байгуулсан "Эрүүл мэндийн Экспо-2025" өдөрлөгт оролцож, марафоны бүртгэл дээр ажилласан. Өдөрлөгт 20 иргэн оролцсон байна. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| 2. | "Суралцагч хот-Арвайхээр" өдөрлөг | Тухай бүр ажиллах | 100% | 100% | Аймгийн ЗДТГ, сумын ЗДТГ, Насан туршийн суралцахуйн төв, Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Суралцагч хот-Арвайхээр" өдөрлөгийн үйл ажиллагаанд 55 иргэн хамруулсан. | | |
| 3. | Үндэсний бөхийн "УЛСЫН АВАРГА" шалгаруулах тэмцээнийг хамтран зохион байгуулах | Тухай бүр ажиллах | 100% | 100% | Үндэсний бөхийн 2025 оны хүүхдийн "Улсын аварга" шалгаруулах анхдугаар барилдаан зохион байгуулагдаж бүртгэл, зохион байгуулалтын үйл ажиллагаанд хамрагдан ажилласан. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| 4. | Бүх нийтийн цэвэрлэгээ | Тухай бүр ажиллах | 100% | 100% | Арвайхээр хотын Захирагчийн албанаас гаргасан хувиарын дагуу бүх нийтийн цэвэрлэгээг жилд 4 удаа зохион байгуулж, багийн нутаг дэвсгэрийн нийт 45 тонн хог хаягдлыг цэвэрлэн ажилласан байна. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.Монгол бичгийн анхан, дунд шатны сургалтад хамрагдана. | 30 кредит | - | 1 | Монгол бичгийн анхан, дунд шатны сургалтад хамрагдаж сертификат авсан. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2. Богино болон чиглүүлэх сургалтад хамрагдах | 24 кредит | 1 | - | ХГБХХГазар, Галт шувуу ТББ-ын хамтарсан "Хүүхдийн хамгаалал ба кейс менежмент" кейс бүрдүүлэлтийн талаар 13 багийн хамтарсан багийн нарийн бичгүүдийг чадавхжуулах 24 цагийн сургалтад хамрагдан сертификат гардан авсан. | 2025.01.13<br>2025.12.01 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:
НИЙГМИЙН АЖИЛТАН ............ Ч.ЦЭВЭЛМАА / Ч.Цэвэлмаа ............ 2025.12.01

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# ЭМТ 2 ДУГААР БАГИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН ЧАДРААБАЛ ОВОГТОЙ ЦЭВЭЛМААГИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Арвайхээр сумын Засаг даргын тамгын газар

Нэгжийн нэр: Эмт 2 дугаар багийн ажлын алба

**1.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| | **Зорилт 1. “Хууль тогтоомж, бодлого шийдвэрийг хэрэгжилтийг ханган ажиллах”** | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.1 | 60 | 10 | 70 ✓ | 70 |
| 2. | Арга хэмжээ 1.1.2 | 60 | 10 | 70 ✓ | 70 |
| 3. | Арга хэмжээ 1.2.1 | 60 | 10 | 70 ✓ | 70 |
| 4. | Арга хэмжээ 1.2.2 | 60 | 10 | 70 ✓ | 70 |
| 5. | Арга хэмжээ 1.2.3 | 40 | 10 | ✓ | 50 |
| 6. | Арга хэмжээ 1.3.1 | 24 | 10 | [illegible] | 34 |
| 7. | Арга хэмжээ 1.3.2 | ~~60~~ 24 | 10 | 70 | 34 |
| 8. | Арга хэмжээ 1.3.3 | ~~60~~ 44 | 8 | 70 | 52 |
| 9. | Арга хэмжээ 1.4.1 | 60 20 | 10 5 | 70 | 25 |
| 10. | Арга хэмжээ 1.4.2 | 60 34 | 10 | 70 | 44 |
| 11. | Арга хэмжээ 1.4.3 | 60 34 | 10 | 70 | 44 |
| 12. | Арга хэмжээ 1.4.4 | 60 30 | 10 | 70 | 40 |
| 13. | Арга хэмжээ 1.4.5 | 60 | 10 | 70 ✓ | 70 |
| 14. | Арга хэмжээ 1.5.1 | ~~60~~ 30 | 10 | ~~70~~ | 40 |
| 15. | Арга хэмжээ 1.5.1 | 60 | 10 | 70 | 70 |
| 16. | Арга хэмжээ 1.5.2 | 60 | 10 | 70 | 70 |
| 17. | Арга хэмжээ 1.5.3 | 60 | 10 | 70 | 70 |
| 18. | Арга хэмжээ 1.5.4 | хайрлаусан хүүхэд ~~60~~ | ~~10~~ | ~~70~~ | — |

603

42x1=
54x1=
38x1=
62x7= 24

70x27=
50x1=
34x8=6
52x1

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 19. | Арга хэмжээ 1.6.1 | 60 | 10 | | 70 |
| 20. | Арга хэмжээ 1.7.1 [illegible] | | | | — |
| 20. | Арга хэмжээ 1.7.2 | 60 | 10 | | 70 |
| 21. | Арга хэмжээ 1.8.1 | 50 | 10 | | 60 |
| 22. | Арга хэмжээ 1.8.2 | 32 | 10 | | 42 |
| 23. | Арга хэмжээ 1.9.1 | 44 | 10 | | 54 |
| 24. | Арга хэмжээ 1.9.2 | 30 | 8 | | 38 |
| **Дундаж оноо** | | 60 | 10 | | 70 |
| **Зорилт 2 “Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх”** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1.1 | 14 | 10 | | 24 |
| 2. | Арга хэмжээ 2.1.2 | 54 | 8 | | 62 |
| 3. | Арга хэмжээ 2.2.1 | 60 | 10 | | 70 |
| 4. | Арга хэмжээ 2.2.2 | 60 | 10 | | 70 |
| 5. | Арга хэмжээ 2.2.3 | 60 | 10 | | 70 |
| 6. | Арга хэмжээ 2.3.1 | 60 | 10 | | 70 |
| 7. | Арга хэмжээ 2.3.2 | 60 | 10 | | 70 |
| | Дундаж оноо | 60 | 10 | | 70 |
| **Зорилт 3. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1.1 | 60 | 10 | | 70 |
| 2. | Арга хэмжээ 3.2.1 | 60 | 10 | | 70 |
| 3. | Арга хэмжээ 3.2.2 | 60 | 10 | | 70 |
| 4. | Арга хэмжээ 3.2.3 | 60 | 10 | | 70 |
| 5. | Арга хэмжээ 3.3.1 | 60 | 10 | | 70 |
| 6. | Арга хэмжээ 3.4.1 | 60 | 10 | | 70 |
| 7. | Арга хэмжээ 3.5.1 | 60 | 10 | | 70 |
| 8. | Арга хэмжээ 3.6.1 | 60 | 10 | | 70 |
| Дундаж оноо | | | | | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. | 60 | 10 | | 70 |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. | 60 | 10 | | 70 |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. | | | | |
| **Дундаж оноо** | | | | | 69,3 |

**2.Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 2.1 | 100 | 15 | 15 |
| 3. | Арга хэмжээ 2.2 | 100 | 15 | 15 |
| **Дундаж оноо** | | | | 15 |

**3.Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | 7 |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | 7 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | 7 |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | 7 |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | 7 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | 7 | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | 7 | |
| **Дундаж оноо** | | | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |

| Дундаж оноо | |
|---|---|

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмээ)-ын биелэлт орно)* | (70 хүртэлх оноо) 59,3 |
| 2. | Мэдлэг ур, чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | (15 хүртэлх оноо) 15 |
| 3. | Хандлага, ёс зүйн, ур чадварын үнэлгээ<br>*(Нэгжийн даргын үнэлгээ)* | (7 хүртэлх оноо) 7 |
| 4. | Хандлага, ёс зүйн, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | (8 хүртэлх оноо) 7,88 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | (.... оноо) |
| Нийт оноо=<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх арга хэмжээний оноо+ Хандлага, ёс зүйн, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )-Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтын дагуу хассан оноо+ Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 89,1. |

***Үнэлгээ өгсөн: Нэгжийн дарга***

ЭМТ 2 ДУГААР БАГИЙН
ЗАСАГ ДАРГА ............................ /Д.МӨНХБАЯР/

*2025.12.01*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

ЭМТ 2 ДУГААР БАГИЙН
НИЙГМИЙН АЖИЛТАН ............................ /Ч.ЦЭВЭЛМАА/

*2025.12.01*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

ЗДТГ-ын дарга ............................ /С.Гантулга/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*